



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 12 сарын 23 өдөр

Дугаар А/119

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Шинэ сэргэлтийн бодлогын 6.1, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 2/05 дугаар тогтоолоор баталсан аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн хэмжээнд Хяналт-шинжилгээ үнэлгээний нэгдсэн систем нэвтрүүлэх ажлыг хариуцан хэрэгжүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Ганболд (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)

Гишүүд: Н.Ганзориг (Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Д.Бямбасүрэн (Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга)

Ч.Эрдэнэбат (Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

О.Батнасан Санхүү, төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Д.Дөмөгтүшиг (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Б.Даваасүрэн (Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн мэргэжилтэн)

2. Ажлын хэсгийн гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, сонгон шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Ганболд)-д үүрэг болгосугай.

3. Дээрх сонгон шалгаруулалттай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга (Б.Даваасүрэн)-д үүрэг болгосугай.

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *Б.Баярсүх*

